

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 2024-2025 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн үр дүн

№	Байгууллагын нэр	Хэрэгжүүлсэн төслийн нэр	Гэрээний дугаар	Мөнгөн дүн	Төслийн хүрээнд хийгдсэн ажил	Төслийн үр дүн
1.	“ЭНДОМЕД дотоод шүүрлийн эмнэлэг”	Чихрийн жишин хэв шинж-1 тэй хүүхэд, өсвөр үеийнхэнд ээлтэй сургууль, цэцэрлэгийн орчныг дэмжих төсөл	002/277	19,090,000	1. ЭХЭМҮТөвийн Дотоод шүүрэл судлалын тасагтай хамтран Чихрийн шижин хэвшинж 1-тэй хүүхдүүдийн бүртгэлийг үндэслэн тэдний эцэг эх, асран хамгаалагчидтай утсаар холбогдон, чихрийн шижинтэй хүүхдүүдийн суралцдаг сургууль, цэцэрлэг болон багш нарын бүртгэл үүсгэж, түүн дээр үндэслэн чихрийн шижин хэвшинж 1-тэй хүүхэд, өсвөр үеийнхний амьдралын чанар, өөрийн хяналт, хүүхдийн эмнэлгээс насанд хүрэгчдийн эмнэлэгт шилжих эмнэлэг хоорондын шилжилтийн бэлэн байдалд судалгаа хийх, тэднийг дэмжих бүлэгт сургалт явуулах боломжтой болсон. 2. ЧШ хэвшинж 1-тэй хүүхдүүд, тэдний багш, эцэг эх, асран хамгаалагч нийт 28 хүнд өдөрлөг зохион байгуулав. 3. МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газартай хамтран, Багшийн хөгжлийн ордонд, ЧШХШ1-тэй хүүхэд өсвөр үеийнхэнд ээлтэй сургууль цэцэрлэгийн орчныг дэмжих сэдэвт сургалтыг зохион байгуулж Улаанбаатар хотын ЕБС ба цэцэрлэгийн эмч, хоолзүйч, тогооч нар нийт 197 хүн оролцов. Өдөрлөг, сургалтын үеэр Олон Улсын Чихрийн Шижингийн Холбооноос гаргасан Чихрийн шижин хэвшинж 1-тэй сурагчдын эцэг, эх, багш, хамт суралцагчдад зориулсан Чихрийн шижингийн тухай ойлголт гарын авлага: • Хүүхдүүдэд зориулсан 11 хуудастай 300 ширхэг • Эцэг эхчүүдэд зориулсан 15 хуудастай 300 ширхэг • Багш нарт зориулсан 35 хуудастай 300 ширхэг • Чихрийн шижинтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан 31 хуудастай 300 ширхэг Хооллолт ба чихрийн шижин • Хүүхдүүдэд зориулсан 13 хуудастай 300 ширхэг • Эцэг эхэд зориулсан 19 хуудастай 300 ширхэг • Багш нарт зориулсан 35 хуудастай 300 ширхэг	100%

					Чихрийн шижинтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан 19 хуудастай 300 ширхэг хэвлүүлэн тараав. (Хавсралт 1)	
2.	“АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль”	Дархан-Уул аймгийн их дээд мэргэжлийн сургуулиудын оюутнуудын амьдралын хэв маяг, эрсдэлт зан үйлийн судалгаа	002/293	4,410,000	- Дархан Уул аймгийн их дээд сургуулиудад суралцаж буй 384 оюутнуудын амьдралын хэв маяг, эрсдэлт зан үйлийн судалгааг хийж, үр дүнг тооцсон. - Их Дээд Мэргэжлийн Сургуулиудын сургуулийн эмч, оюутны холбоотой хамтран Эрсдэлт зан үйлийн талаарх буюу архи, тамхи, хөдөлгөөн, хооллолт, донтолт гэсэн 5 сэдвийн хүрээнд хичээл бэлтгэн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн оюутнуудын дунд Эм найруулагчийн 1, 2, 3 дамжааны 90, Лабораторийн техникчийн 2, 3 дамжааны 35, Сувилагч, сувилахуй 2, 3, 4 дамжааны 45, АСБ, ЭМСБ 1, 2 дамжааны 84, Эх барихуй 14 нийт 268 оюутанд сургалтыг зохион байгуулав. Сургалтад хамрагдсан оюутнуудаас өөрийн хүсэлтийг үндэслэн 10 оюутныг сонгон авч сургагч багшаар бэлтгэсэн. - Эрүүл амьдралын хэв маяг, эрсдэлт зан үйлийн талаарх гарын авлага 77 хуудастай – 300 ширхэг хэвлүүлэн сургалтын үеэр тараасан. (Хавсралт 2) - Контент (CD-1ш) - Контент 1: ЭЗҮ 1 мин 52 сек - Контент 2: ЭЗҮ 32 сек	100%

					• Контент 3: ЭЗХ 1 мин 52 сек • Зөвлөмж 4: 25 сек • Зөвлөмж 5: 1 мин 05 сек • Зөвлөмж 6: 1 мин 05 сек • Зөвлөмж 7: 26 сек	
3.	“Ньючанэл ХХК”	Та амьдралаа өөрчилмөөр байна уу?” зорилтод нэвтрүүлэг, 40 минутаар 9 дугаар (ТВ9 суваг)	002/278	58,900,000	1. Архины хамааралтай, орон гэргүй тэнэмэл амьдралаар амьдарч байгаад Нийгэм хамгааллын тусгай төвөөс үйлчилгээ авч буй иргэдээс архи, согтууруулах ундааг удаан хугацаагаар хэтрүүлэн хэрэглэдэг архинд донтсон дөрвөн иргэнийг өөрийнх нь болон гэр бүлийнх нь хүсэлтийн дагуу сонгон авсан. Нэг иргэнийг өөрийнх нь болон нэвтрүүлэгт ирсэн иргэдийн хүсэлтийн дагуу сонгож нийт таван иргэнийг нэвтрүүлгийн оролцогчоор авсан. 2. Таван оролцогчийг Аддиктологийн төвийн олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, батлагдсан 4С хөтөлбөрийн хүрээнд 14 хоногийн архинаас гаргах цогц эмчилгээний хөтөлбөрийн дагуу эмнэлэгт хэвтүүлэн, эмчилгээнд хамруулав. 3. Өдөр бүр мэргэжлийн эмч нар эмийн эмчилгээ, сургалт, сэтгэлзүйн эмчилгээ, иог, бясалгал, хөдөлмөр эмчилгээ, хандлагаар анагаахуй, миннесото зэрэг хичээлүүдэд хамруулан эмчилгээний үйл явцыг тухай бүрд нь баримтат нэвтрүүлэг хийв. 2025 оны 4-р сарын 19-ны өдрөөс эхлэн 6-р сарын 22-ны хооронд ТВ9 телевизээр хуваарийн дагуу 9 цуврал нэвтрүүлэг цацагдсан. Линк: https://www.facebook.com/reel/1898645040864891 https://youtu.be/70vMNAFLTfU?feature=shared https://youtu.be/gzvih4B4wUE?si=Zopl9iFHe8lQSp9u https://youtu.be/zHZZRRbyvuQ?si=ZviplZcM5jF1hCvs	100%

					https://youtu.be/Nh7mD6A7hmA?si=FXL4b17I2BuEN9mX https://youtu.be/y_mcv0QyKg4?si=0d0CQRXdYqxMEuvK https://youtu.be/C_MJlqFaA6M?si=vnZoSqPuMuG2MB0p https://youtu.be/a1gOc2PgKmA?si=tarXSsFysedEeLKT Нэвтрүүлгийн дараа 4 оролцогчдын үр дүнг үнэлэн 40 минутаар 4 цуврал нэвтрүүлэг цацагдсан.	
4.	“Хаганэ Ло Фирм ХХК”	Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах хууль зүйн судалгаа	002/279	61,100,000	1. 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2. Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан “Гадаад улс орнуудын эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалт” 237 хуудас бүхий ном хэвлүүлсэн.	100%
5.	“Бест Мониторинг ХХК”	Сайт болон сошиал судалгаа	002/280	15,000,000	1. Эрүүл мэндийн талаарх мэдээ мэдээлэл сурталчилгааны онлайн орчны судалгааг GoGo.mn, News.mn, Zarig.mn, Ubnn.com, Urug.mn, eguur.mn, ikon.mn, medee.mn Цахиур.mn, Ergelt.mn сайтуудад хийж эрүүл мэндийн талаарх мэдээлэл сурталчилгааг хэрхэн үр дүнтэй хийх талаар зөвлөмж боловсруулав. 2. Эрүүл мэндийн мэдээллийг хаанаас ямар байдлаар хаанаас авдаг талаарх судалгааг насны бүлгээр ангилан 1000 хүнээс авсан асуулга авч үр дүнг үнэлэн зөвлөмж боловсруулсан.	100%

6.	“АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль”	Дархан-Уул аймгийн иргэдийн эмийн зохистой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх	002/213	4,025,000	1. Дархан-Уул аймгийн 306 иргэдийн эмийн зохистой хэрэглээний эрүүл мэндийн боловсролын өнөөгийн байдлыг судалж иргэдийн эмийн хог хаягдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлсэн. 2. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС-д эм зүйч мэргэжлээр суралцаж байгаа 60 оюутан, эм найруулагч мэргэжлээр суралцаж байгаа 90 оюутнуудад 2 удаа танхимын сургалтыг зохион байгуулсан. Төслийн гишүүд болон сургагч багш нар багт хуваарилагдан сургалтуудыг зохион байгуулсан. 3. Дархан Уул аймаг дахь салбар АУС-ийн эм зүйн чиглэлээр суралцаж байгаа эм зүйчийн 1-3, эм найруулагчийн 1-3-р дамжааны 150 оюутнаас 10 оюутныг сургагч багшаар бэлтгэв. 4. Дархан уул аймгийн иргэдэд эмийн зохистой хэрэглээний сургалтыг 2 удаа 150 оюутнуудад зохион байгуулсан. 5. Иргэдэд зориулсан эмийн зохистой хэрэглээний гарын авлагыг боловсруулан Өнөөдрийн зохистой хэрэглээ-Эмийн зохистой хэрэглээний гарын авлага 105 хуудастай – 300 ширхэг (Хавсралт 3) “Мөнхийн үсэг ХХК-ны Дархан-Уул аймаг дахь салбар хэвлэлийн компаниар хэвлүүлж сургалтын үеэр тараасан. 6. Дархан-Уул аймагт гэрийн нөхцөлд гарсан эмийн хог хаягдлыг АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС-ийн хичээлийн А, Б байранд хүлээн авах шилэн хоргыг байрлуулан ажиллуулж байна. 7. Контент (CD-1ш) • Контент 1: ЭЗХ 10 мин 36 сек • Контент 2: ЭЗХ 6 мин 46 сек • Контент 3: ЭЗХ 3 мин 57 сек • Зөвлөмж 1: 47 сек • Зөвлөмж 2: 60 сек	100%
----	---	---	---------	-----------	--	------

7.	“Монголын цусны өвчин судлалын нийгэмлэг”	Жирэмсэн эмэгтэйчүүдийг цус багадалтаас сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох нь	002/281	25,100,000	1. Баянзүрх, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн нийт 70 эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч бага эмч нар өрхийн эмнэлэг эмч, нийгмийн ажилчдад сургалт оров. 2. Эмч нарыг сургасны дараа зорилтот бүлгийн 80 жирэмсэн эмэгтэйчүүдэд 2 удаа сургалт зохион байгуулсан. Сургалтын өмнөх сорилын онооны дундаж хувь 35% байсан бол сургалтын дараах сорилын үнэлгээний дундаж 86.8% болж сайжирсан нь эхчүүдийн мэдлэгийн түвшин сайжирч, тухайн сэдвийн талаарх ойлголт нь илүү гүнзгийрсэнийг илтгэж байна. 3. “Жирэмсний үеийн төмөр дутагдлын цус багадалт” 28 хуудастай 90 ширхэг гарын авлагыг сургалтын үеэр тараав. (Хавсралт 4) 4. Тараах материал 1 төрөл-100ш (Хавсралт 4)	100%
8.	“Повер Прогресс ХХК”	Эрүүл мэндийн нэвтрүүлэгт судалгаа шинжилгээ хийх	002/282	19,500,000	1. 2024 оны 6-р сарын 1-ээс 12-р сарын 31 хүртэл хугацаан дахь 10 суваг телевизийн Эрүүл мэндийн нэвтрүүлгийн мониторинг судалгааг нийт эфирийн минут болон эрүүл мэндийн нэвтрүүлгийн минут, эзлэх хувийг тооцож судалгааны ажлын зөвлөмж боловсруулав.	100%
9.	“Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг”	Электрон тамхи /вэйп/, тамхи, мансууруулах бодисын хор нөлөөллөөс урьдчилан сэргийлэх асуудал	002/283	9,225,000	1. МУБИС, АШУҮИС, ХААИС, ҮБХИС, МУИС, ШУТИС-ын 515 оюутан, 3 сургуулийн 30 сурагчдад электрон тамхи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөөллийн талаар ХДХВ/ДОХ/БЗДХ-ын мэдлэг олгох сургалт зохион байгуулсан. Сургалтын үеэр гарын авлага: (Хавсралт 5) Та тамхиа хаяж чадна (20 хуудастай) 300 ширхэг, тараах материал: (Хавсралт 5) 2 төрөл: Мансуурлаас сэргийлье 500 ширхэг, Тамхиа хаях 6 зарчим 500 ширхэгийг хэвлүүлэн тараасан. 2. Дэлхийн тамхи татдаггүй өдрийг тохиолдуулан Ангийн андууд амьдралын найзууд ТББ-тай хамтарч АХА тэмцээн 1, 24, 31-р сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан нь сурагчдын эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлж, тамхинаас урьдчилан сэргийлэх дадал төлөвшүүлэх, мөн сургууль-ТББ-нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд эерэгээр нөлөөлж байна.	100%

10.	Ногоон хүрээлэнгийн багш нар	Сэтгэцийн эрүүл мэнд архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх	002/286	36,870,000	1. Өмнөговь аймагт 130 хүн, Булган аймагт 45, Дархан уул аймагт 31, Хөвсгөл аймагт 30, Орхон аймагт 30, Өвөрхангай аймагт 30, Налайх дүүрэг, Улаанбаатар хотын иргэд олон нийтдэд 16 удаагийн сургалтыг сэтгэцийн эрүүл мэндийн архи тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх сургалт явуулж “Тамхинаас гарах хөтөлбөр” 80 хуудастай гарын авлага 2000 ширхэгийг, өсвөр насныханд болон эцэг эхчүүдэд зориулсан 3 төрлийн тараах материал 2500 ширхэгийг түгээв. 2. Нийслэлийн 25-р сургуулийн 8 багштай хамтран “САЙН БАГШ ЭЦЭГ ЭХ ХҮҮХЭД” сургалтыг 2025.04.10 наас 6-р сарын 23-ны хугацаанд зохион байгуулав. 3. СЭМҮТ эмч нар аймгуудын AAA-ийн клубийн иргэдтэй уулзан ганцаарчилсан зөвлөгөөг өгсөн нь иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, AAA клубийн үйл ажиллагааг бэхжүүлж, иргэдийн зан үйл, хандлагад эерэг өөрчлөлт оруулах, эрүүл мэндийн тусламжийг ойртуулсан давуу талтай байна. 4. Контент: Фэйсбүүк пэйжид 4 төрлийн контент байршуулав. - Тамхи танд юу өгсөн бэ? https://www.facebook.com/reel/2348396922245716 - Уушги чинь зөвхөн агаарт зориулагдсан. Вэйп биш. https://www.facebook.com/reel/766598373081593 - Vape vs Тамхи https://www.facebook.com/reel/826264589874749 - Архи уухаар таны нүүр улайж загатнадаг уу?	100%
11.	“Ангийн андууд амьдралын найзууд” НҮТББ	Архи, электрон тамхи, утаат тамхины (янжуур) хорт нөлөөллөөс сэргийлэх нь	002/288	9,660,000	1. Архи, электрон тамхи, утаат тамхины (янжуур) хорт нөлөөллөөс сэргийлэх нь сэдвээр Нийслэлийн БГД-ийн 40, СХД-ийн 9, БЗД-ийн 85-р сургууль, СБД-ийн 1, 31, Чингэлтэй дүүргийн 24-р сургуулийн нийт 150 хүүхдийг хамруулсан.	100%

					2. Архи, электрон тамхи, утаат тамхины хорт нөлөөллөөс сэргийлэх нь гарын авлага 28 хуудастай-400 ширхэгийг сургалтын үеэр тараасан. (Хавсралт 7)	
12.	“Баяах маркетинг ХХК”	“Та сэргийлж чадна” иргэдэд зориулсан эрүүл байх талаар мэдэг олгох подкаст, рийл бэлтгэх төсөл	002/285	36,764,000 Урьдчилгаа 70% буюу 25,734,800-г олгосон.	1. Эрүүл зөв, зохистой хооллолт гэж бэ ? /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 2. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх нь /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 3. Хөдөлгөөний ач тус, алхалт, дасгал /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 4. Монголын үндэсний уламжлалт идээ, ундаа /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 5. Амны хөндийн эрүүл мэнд /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 6. Эрт илрүүлгийн ач холбогдол /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 7. Чихрийн шижин өвчнөөс сэргийлэх нь /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ 8. Архи, согтуулах ундааны хортой хэрэглээ /Подкаст 5-10 мин, рийл 90 сек/ сэдвээр цуврал цуврал подкастуудыг 2025 оны 08 сарын 20-ны өдрөөс “Баяах маркетинг” ХХК-ий албан ёсны 5,200 дагагчтай BayahmarketingMongolia хуудсанд байрлуулсан. Рийл: 1. https://www.facebook.com/reel/4056274651289613 2. https://www.facebook.com/reel/864641506084388 3. https://www.facebook.com/reel/1917400709202893 4. https://www.facebook.com/reel/1217098336930805 5. https://www.facebook.com/reel/1837110137678842 6. https://www.facebook.com/reel/1103411708356533 7. https://www.facebook.com/reel/2025650548254582 8. https://www.facebook.com/reel/1177398210514096 Подкаст: 1. https://www.facebook.com/reel/838331671937542 2. https://www.facebook.com/reel/1365877191745235 3. https://www.facebook.com/reel/726923733787044 4. https://www.facebook.com/reel/669791592872073 5. https://www.facebook.com/reel/1490701245528701	100%

					6. https://www.facebook.com/reel/1527996778361529 7. https://www.facebook.com/reel/758754343723553 8. https://www.facebook.com/reel/1444267063292821	
13.	“Эс Эс Жи Өү” ХХК, зүүм студи	Нийгмийн эрүүл мэндийг хуулиар хамгаална” баримтат кино, цахим ном төсөл	002/276	45,700,000	1. “Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн түүх ном” 97 хуудас бүхий цахим ном 2. “Нийгмийн эрүүл мэнд түүх өгүүлнэ” 39 мин 07 сек бүхий баримтат кино Линк: https://www.youtube.com/watch?v=wTcXoepPUBc Рийл бичлэгүүд: Линк: https://www.facebook.com/reel/1531770624520396 https://www.facebook.com/reel/1921902732060935 https://www.facebook.com/reel/872178815236666 https://www.facebook.com/reel/24683858941314353	100%
14.	“Эмнэлзүйн бичил амь судлалын Монголын нийгэмлэг”	Эмнэлэгт хандан үйлчлүүлэгсдийн антибиотикийн зохистой хэрэглээг дэмжих, эмэнд тэсвэржсэн бичиг биетний колонизаци бүхий үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхний халдвараас сэргийлэх зөв дадлыг дэмжих интервенц судалгааны төсөл	002/284	48,000,000	1. Улсын болон аймаг, дүүргийн 41 эмнэлэгийн халдварын сэргийлэлт хяналтын албатай холбогдож сургалтын хэрэгцээг тодорхойлох-Эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвар, халдвараас сэргийлэх арга хэмжээний талаарх сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлох зорилгоор дараах 4 бүлэг 81 асуумжаар үнэлсэн. 2. “ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРЖСЭН БИЧИЛ БИЕТНИЙ ЭМЧИЛГЭЭ, ОНОШИЛГОО, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА” сэдэвт 1 багц цагийн танхимын сургалтад нийт 123 хүн хамрагдсан. Линк: https://www.facebook.com/share/p/1G8rd1d2F6/?mibextid=wwXlfr 3. “Олон эмэнд тэсвэржсэн бичил биетний эмчилгээ, оношилгоо халдварыг сэргийлэлт хяналтын орчин үеийн чиг хандлага” сургалтын эхний хэсэг 2025 оны 10-р сарын 31-ны өдөр АШУУИС-ийн Дархан-Уул	100%

				аймгийн АУС-ийн 2 давхарийн хурлын өрөөнд танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдлаа. Уг сургалтанд Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүд, Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн эмч, багш, ажилчид танхимаар нийт 39 хүн, цахимаар 100 хүн хамруулсан. 4. 2025 оны 12-р сарын 18-ны өдөр Налайх дүүргийн нэгдсэн эмнэлгийн хурлын танхимд зохион байгууллаа. Налайх дүүргийн нийт 23, Багануур дүүргээс эрүүл мэндийн 4 ажилтан танхимаар хүрэлцэн ирж оролцов. Танхимаар 27, цахимаар 35 буюу нийт 62 эмнэлгийн ажилтан оролцлоо. Сургалтанд АУ-ны доктор, профессор Ч.Баттогтох цахимаар лекц уншин бусад 3 сургагч багш танхимаар хичээл оров. 5. 2025 оны 12-р сарын 19-ний өдөр Төв аймгийн эрүүл мэндийн газрын хурлын өрөөнд боллоо. Сургалтанд танхимаар нийт 21, онлайнаар 33 хүн хамрагдав. 6. Эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвартай эмчлүүлэгчийн ар гэрийнхний баримтлах дэглэм сэдвээр ард иргэдэд зориулсан мэдээлэл суртачилгааны материал 500 ширхэгийг, эрүүл мэндийн байгууллагад олон эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвараас сэргийлэх зарчим” эмч, эмнэлэгийн ажилчдад зориулсан мэдээлэл суртачилгааны материал 500 ширхэгийг бэлтгэн сургалтын үеэр тараав. 7. <i>Мэдээлэл суртачилгааны хэвлэмэл материал, видео контент өөрийн пэйжид байршуулсан:</i> 1. <i>Vancomycin resistance Enterococci</i> -талаар нийтлэг тохиолдлыг дүрсжүүлэн 1мин 38 секундйн видео бичлэг	
--	--	--	--	---	--

					2. <i>MRSA, CRE</i> -талаар мэдээлэл олгох видео 3. <i>MRSA</i> -ийн талаар мэдлэг олгох видео	
15.	“Онч мутар Уламжлалт анагаах ухааны эмнэлэг”	Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалъя	002/287	34,650,000	1. Уламжлалт анагаах ухааны хялбар аргуудыг урьдчилан сэргийлэх болон эмчилгээнд нэвтрүүлж буй байдлын тандалт судалгааг анхан болон лавлагаа шатлалын 74 эмч, мэргэжилтнийг хамруулан явуулсан. Уламжлалт анагаах ухааны талаарх ойлголтын талаарх 133 иргэнээс судалгаа авсан. 2. Судалгааны үр дүнд үндэслэн 2 төрлийн подкаст, 3 төрлийн рийл бичлэгийг цахим хуудсанд байршуулсан. 3. 2 төрлийн подкаст, 3 төрлийн рийл бичлэг: • Дугаар 1-“Уламжлалт анагаах ухаан ба улирлын тохируулга” 10мин 29сек https://youtu.be/fdFT2EfR-A4 • Дугаар 2-“Хийн, шарын, бадганы онол ба хувь хүний онцлог” 17мин 22сек https://youtu.be/Erf7oUeA7Dc 4. Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалъя. 22 хуудас бүхий гарын авлага 400 ширхэгийг тараасан.	100%
16.	“Монголын химич, химийн инженер технологичд ын холбоо”	Монгол орны томоохон уул уурхай, баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үе дэх зарим хүнд металлын байгаль орчин, уур амьсгал, хүний эрүүл мэндийн нөлөөллийн судалгаа, үнэлгээ	002/294	160,832,000	Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 8 дугаар сарын 07-ны өдөр Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр гарч, Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрлийн тогтоол нь төсвийн жилийн санхүүгийн хаалт хийгдсэний дараа буюу Монголын химич, химийн инженер технологичдын холбооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр А/76 тоотор баталгаажин ирсэн тул 2025 онд санхүүжилт олгогдоогүй болно.	100%